



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/257

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.2, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.5.5 дэх хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сурын харвааг хөгжүүлэх зорилгоор "Урианхай сурын баруун бүсийн чуулга харвааны аварга шалгаруулах" арга хэмжээнд зарцуулах 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг батлагдсан төсвөөс гаргаж зарцуулах эрхийг Бугат сумын Засаг дарга (Я.Мятав)-д шилжүүлсүгэй.

2. Арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг Бугат сумын Засаг дарга (Я.Мятав)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ